

АНГЛИ ТҮРЭГ МОНГОЛ ХЭЛНИЙ ТИЙН ЯЛГАЛ БА ЗАЛГАА ЁСНЫ ТУХАЙ

М. Ууганбаяр*

В. Дашдаваа тийн ялгал нь үндэслэгч болоод түүний төрлийн бүтцийн шинж байржихийн харьцаанд хамаарах өгүүлбэрзүйн хүрээлэлийн хоорондох харьцаа бөгөөд тийн ялгалын оноолтыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэх энэхүү харьцааг захирах ёс гэдэг тухай бичсэн ба

1. А нь орой байх

а. А нь В -г их эрхшээх

б. А ба В нь залгаа бол

в. А нь В -г захирна гэжээ.(Дашдаваа 2012: 20)

Захирах ёсны дагуу тухайн тийн ялгалыг шаардах нэрийн хэлхэцтэй залгаа байх тийн ялгалыг оноогч шаардагдах ба англи хэлнээ

2. I believe very deeply that she is genius

(Би итгэдэг маш гүнзгий гэж тэр сод ухаантай)

Би түүнийг сод ухаантай гэж маш гүнзгий итгэдэг

гэсэн өгүүлбэрт тийн ялгалыг зөвшөөрч буй нөхцөлд *deeply* дайвар үг үйл үг нөхөлтийн хэлхцийн завсар орж байгаа нь *that she is genius* гэх нөхөлтийн хэлхэц тийн ялгалыг оноохгүй байгаатай холбогдох бол

3. I will very deeply her to be genius

Би маш гүнзгий түүнийг сод ухаантай гэж

гэх өгүүлбэр хэл зүйн бус болж байгаа нь бүтцийн тийн ялгалын залгаа ёсны нөхцлийг зөрчиж буйгаас хамаарах ажээ. (Дашдаваа 2012: 20)

Өөрөөр хэлбэл тийн ялгалын онолын үүднээс бүтцийн тийн ялгалын бүтцийн шинж залгаа ёсны зарчимд тулгуурладаг. Хэлхцийн орой ямар нэг нэрийн хэлхцэд бүтцийн тийн ялгалыг оноохын тулд тухайн орой болон нэрийн тийн ялгал залгаа байрлалтай байх хооронд нь өөр махбод орохгүй байх ёстой гэсэн үг. Жишээлбэл:

4. I like ice cream very much

Би мөхөөлдөст маш их дуртай.

Гэтэл

5.*I like very much ice cream

*Би маш их мөхөөлдөст дуртай

гэх өгүүлбэрт буй *very much* хэмээх махбод *ice cream* гэх тусагдахуун түүнд тийн ялгал оноох үйл үгийн хооронд орсноороо тийн ялгал оноолтын хэрэгжилтэд хориг үүсгэж байна.

*Монгол Улсын Их Сургууль

Англи хэлнээ тийн ялгалыг оноогч оноогдогч залгаа байвал үйл үгийн нөхөгчийн байрлалд байх нэрийн хэлхцэд бүтцийн тийн ялгалыг онооно.

Н. Э .Үзүн залгаа ёс нь бүтцийн тийн ялгал дотоод тийн ялгалыг зөв ялгадаг гээд дотоод тийн ялгал нь бүтцийн тийн ялгал биш тул оноогдож буй нэрийн хэлхцэд нь энэхүү нэрийн хэлхцэд айн хувьд эрхшээж захирч сэдэгчийг оноох айтай залгаа байх шаардлагагүй байдгийг түрэг хэлнээ

6. Ali eve dün baktı

Али өчигдөр гэрээ харав

гэх жишээнд чиглэх буюу дотоод тийн ялгалд оноогдсон *ev* гэх нэрийн хэлхцэд захирч буй үйл үгтэйгээ залгаа байрлахгүй байгаагаар үзүүлжээ. (Үзүн 2000: 203)

Гэхдээ залгаа ёс нь бүтцийн тийн ялгал үгзүйн тийн ялгал болдог түрэг мэтийн хэлнээ үгзүйн тийн ялгалд оноогдсон нэрийн хэлхцүүд өөрт нь тийн ялгал оноох оройтойгоо залгаа бус байх аж.

7. Ali kitabı dün okudu

Али ном өчигдөр уншив

Энд заахын тийн ялгал буюу бүтцийн тийн ялгалыг хүлээн авсан *kitabı* хэмээх нэрийн хэлхцэд, тийн ялгал оноогч үйл үгтэйгээ залгаа байрлалтай биш байна. Түрэг хэлнээ англи хэл лүгээ адилаар заахын тийн ялгалыг оноох тусах үйл үг тусагдахууны хооронд өөр махбод орж болдоггүй байна .

8. Ali bugün kitap okuyor

Али өнөөдөр ном уншиж байна.

9.*Ali kitap bugün okuyor

Али ном өнөөдөр уншиж байна.

Энд сүүлчийн жишээнд *kitab* заахын тийн ялгалын ил бус хэлбэр *okuyor* (унших) хэмээх үйл үгийн хоорнд *bugün* (өнөөдөр) хэмээх махбод ороход тийн ялгалыг оноож болохгүй байгаа ба тийн ялгалын шүүлтүүрт үлдэн хэл зүйн бус өгүүлбэр болжээ.

Гэхдээ түрэг хэлний энэхүү залгаа ёс туйлын бус бөгөөд заахын тийн ялгалтай нэрийн хэлхцэд үйл үг залгаа бус ч байж болох ажээ.

Жишээ нь:

10. Ali bir kitap dün aldı bir kitap bugün

Али нэг ном өчигдөр авав. Нэг ном өнөөдөр

11. Ali kitap da (bile) dahi aldı

Али номыг ч авав.

Харин В. Дашдаваа монгол хэлний тийн ялгалыг зөвшөөрөх ёсны хувьд

12. Дулмаа тэр номыг номын санд орхисон

гэсэн өгүүлбэрт номын санд гэх орны дайвар үг тусагдахуун үйл үгийн хооронд орж байгаа бөгөөд тусагдахуунд заахын тийн ялгал оноогдож байгаа бол

13. Дулмаа Баттай өнөөдөр уулзсан

гэх өгүүлбэрт цагийн дайвар үг тусагдахуун дайвар үгийн хооронд орж байгаа бөгөөд тусагдахуунд заахын тийн ялгал оноогдож байна. Үүнээс үзэхэд, монгол хэлнээ заахын тийн ялгалыг зөвшөөрөх залгаа ёсны зарчим хэрэгжихгүй гэжээ. (Дашдаваа 2012:20)

Summary

In this article author touches upon the case and adjacency in English Turkish and Mongolian. From the point of view of case theory in Universal Grammar structural cases shows its peculiarities on adjacency and while in English and Turkish accusative cases adjacency principle realizes and Mongolian accusative does not behave like it.

Ном зүй

- Chomsky N., (1957). *Syntactic Structures*. The Hague: Mouton
- Chomsky N., (1965). *Aspects of the Theory of Syntax*. Cambridge: The MIT Press
- Chomsky N., (1981) *Lectures on Government and Binding*. Foris, Dordrecht,
- Chomsky, N. (1986) *Knowledge of Language its Nature, Origin and Use*, Praeger, New York
- Chomsky N., (1988) *Language and Problems of Knowledge: The Managua Lectures*. Cambridge, Mass.:MIT Press.
- Cook V. J., (1988) *Chomsky's Universal Grammar. An Introduction*. Basil Blackwell.
- Cook V. J., Newson M., (1996) *Chomsky's Universal Grammar. An Introduction*. Basil Blackwell.
- Dashdavaa V., (2012) *A Study on Case in English and Mongolian* PhD dissertation, Kookmin University. Seoul Korea
- Fromkin, V. Rodman, R. and Hyams, N. /2003/ *An Introduction to Language*, Thomson/Heinle
- Fillmore C. J., (1968) *Lexical Entries for Verbs* *Foundations of Language*, 4.
- Gruber, J. S., (1965) *Studies in Lexical Relations*, PhD dissertation, MIT, Cambridge, Mass.
- Haegeman L., (1994) *Introduction to Government and Binding theory*. Blackwell,
- Jackendoff R. S., (1972) *Semantic Interpretation in Generative Grammar*, *Semantic Interpretation*, MIT, Cambridge, Mass.
- Marantz, A. (1984) *On the Nature of Grammatical Relations*, MIT Press, Cambridge, Mass
- Matthews P. H., (2000). *Oxford Concise Dictionary of Linguistics*. Oxford: Oxford University Press
- Radford, A. (1988) *Transformational Grammar*, Cambridge University Press
- Radford, A. (1997) *Syntax: Minimalist Introduction*, Cambridge University Press